

АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ (2009 ОНЫ ЭХНИЙ 3 САРЫН БАЙДЛААР)

I. ТӨСӨВ: Аймгийн төсвийн орлогод 549.2 сая төгрөг орж төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 107.2 хувьтай байна. Нийт орлогын 15.0 хувь шилжүүлгийн орлого байна. Аж ахуйн нэгжийн орлогын татвар 61.0 хувь, нэмэгдсэн өртгийн татвар 9.0 хувиар тасарч байна. Сумдын төсвийн орлогод 511.3 сая. төгрөг орж төлөвлөгөө 103.8 хувийн биелэлттэй байна.

Төсөвт газруудын өглөг 431.6 сая. төг байгаагийн 14.5 хувийг түлш халаалтын зардал, 38.4 хувийг цалин, 10.4 хувийг нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, 8.4 хувийг хоолны эзэлж байна. Аймгийн дүнгээр төсвийн урсгал зардал 6443.0 сая. төгрөг болж төлөвлөгдсөн зардлын 92.8 хувийг санхүүжүүлсэн байна.

II. АРИЛЖААНЫ БАНК. Арилжааны банкуудын зээлийн өрийн үлдэгдэл 36975.3 сая төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 0.9 хувь буюу 305.5 сая төгрөгөөр өссөн байна. Банкуудын хугацаа хэтэрсэн зээл 763.9 сая. төгрөг байна. Иргэдийн хугацаатай болон хугацаагүй хадгаламжийн үлдэгдэл 12060.1 сая төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 79.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

III. ТЭТГЭВЭР ТЭТГЭМЖ: Нийгмийн даатгалын сангуудын орлого 3530.9 сая төгрөг болж төлөвлөгөө 101.4 хувиар биелж, бүх төрлийн тэтгэвэр, тэтгэмж авагчдад 3241.5 сая төгрөгийн тэтгэвэр, 101.9 сая төгрөгийн тэтгэмж олгожээ. Эмнэлгийн санхүүжилтэд 331.6 сая. төгрөг олгосон байна. Нийгмийн даатгалын шимтгэлд төсөвт газрууд болон аж ахуйн нэгжүүдээс нийт 41.3 сая төгрөгийн авлагатай байна.

Нийгмийн халамжийн сангаас 62746 хүнд 3023.7 сая төгрөгийн тэтгэвэр тэтгэмж олгожээ. Халамжийн тэтгэврийг 2099 хүнд 251.4 сая. төгрөг, нөхцөлт мөнгөн тэтгэмжийг 1692 хүнд 99.5 сая. төгрөг, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай 1692 иргэнд 99.4 сая. төгрөг, хүн амын хөгжлийг дэмжих чиглэлээр олгож буй хүүхдийн мөнгөн тэтгэмжийг 42119 хүүхдэд 382.7 сая. төгрөг, шинээр төрсөн 668 хүүхдэд 668.0 сая. төгрөг, шинэ гэр бүл болсон 426 өрхөд 213.0 сая. төгрөг, алдар цолтой 43 ахмадад 201.6 сая .төгрөг, алдарт эхийн одонтой 6352 хүнд 410.9 сая. төгрөгийг тус тус олгосон байна.

IV. ХӨДӨӨ АЖ АХУЙ: Мал аж ахуй: Оны эхний хээлтэгч малын 33.2 хувь буюу 463811 толгой эх мал төллөж, гарсан төлийн 96.9 хувьтай бойжиж байна.

Оны эхний малын 0.7 хувь болох 25607 толгой том мал зүй бусаар хорогдсон нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 60.7 хувиар бага

байна. Гучинус, Хайрхандулаан, Нарийнтээл сумдын хорогдол нийт хорогдлын 75.6 хувийг эзэлж байна.

V. АЖ ҮЙЛДВЭР: Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 813.0 сая төгрөг болж өнгөрсөн оны мөн үеийнхээс 30.7 хувиар өссөн байна. а. Нийт үйлвэрлэлтийн 23.4 хувийг нүүрс олборлолт, 28.8 хувийг хүнсний бүтээгдэхүүн архи үйлдвэрлэлт, 20.1 хувийг цахилгаан дулаан үйлдвэрлэлт, 27.5 хувийг бусад /оёдол, гутал, модон эдлэл /зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэлт тус тус эзэлж байна.

Оны үнээр 787.1 сая төгрөгийн борлуулалт хийсэн нь урьд оны мөн үеийнхээс 30.1 хувиар өссөн байна. Өнгөрсөн онтой харьцуулахад үйлдвэрлэлт, борлуулалт өсч байгаа нь үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний үнэ өссөнөөс өсөлт харагдаж байна.

VI. ХОЛБОО, ТЭЭВЭР, ХУДАЛДАА: Холбооны тарифын орлого урьд оны мөн үеэс 28.7 хувиар буурч, 78.5 сая төгрөг болсны дотор хүн амаас орсон орлого 52.7 хувиар буурч 21.4 сая төгрөгт хүрсэн байна. Телефон цэгийн тоо 2091 болсон байна. Тээврийн үйлчилгээ эрхэлдэг иргэд нийт 2.8 мян. тн ачаа, давхардсан тоогоор 21.2 мянган зорчигч тээвэрлэж, 265.0 сая төгрөгийн орлоготой ажиллаж өмнөх оны мөн үеэс 1 дахин өссөн байна.

Худалдааны чиглэлийн аж ахуй нэгж, иргэд 2105.1 сая төгрөгийн бараа гүйлгээ хийсэн нь урьд оны мөн үеэс 9.2 сая төгрөгөөр өслөө.

VII. ЭРҮҮЛ МЭНД: Аймгийн дүнгээр 728 эх амаржиж 732 хүүхэд төрсөн нь өмнөх онтой харьцуулахад 54-өөр их байна. 1 хүртлэх насандаа 15 хүүхэд эндэж өмнөх оныхоос 13-аар буурсан байна. Халдварт өвчнөөр өвчлөгчид 275 бүртгэгдэж урьд онтой харьцуулахад 92 –аар буурсан байна.

VIII. АЖИЛГҮЙЧҮҮД: Хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлсэн ажилгүйчүүдийн тоо 2334 болж 19.4 хувь нь 16-34 насны залуучууд, 65.7 хувь нь бүрэн ба бүрэн бус дунд боловсролтой хүмүүс байна. Энэ сард нийт 81 хүн ажилд орсон байна.

IX. ГЭМТ ХЭРЭГ: Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 98 байгаа нь урьд оны мөн үеэс 12-аар буурч, гэмт хэргийн улмаас 15 хүн нас барж, 41 хүн гэмтэж, ААНБ иргэдэд 60.0 сая төгрөгийн хохирол учирсны 35.6 саяыг нь нөхөн төлүүлсэн байна. Гэмт хэрэгт холбогдсон сэжигтний 39.6 нь согтуугаар хэрэг үйлдсэн байна. Энэ хугацаанд 342 хүн эрүүлжүүлэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 99-өөр өссөн байна.

СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

